



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/499

Мандалговь

Нохой, муурыг бүртгэлжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.8, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд гэрийн тэжээвэр амьтан нохой, муурыг бүртгэлжүүлэх, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга болон туулгалтад хамруулах арга хэмжээг жил бүр зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Гэрийн тэжээвэр нохой, муур бүртгэлжүүлэх, туулгалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүй нэгдсэн удирдлагаар ханган, технологийн хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар (И.Жавхлант)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/500

Мандалговь

Мал угаалгын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалт, 21.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж сумын бүх бог малыг угаалгад хамруулах ажлыг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 05-ны хүртэл хугацаанд зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Мал угаалгын шинээр баригдсан ванны ашиглах, хуучин ваннуудыг засварлаж, малчдын оролцоог хангаж Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлтэй эмийн бодисыг ашиглан бүх бог малыг шумбуулж угаахыг сум багийн Засаг дарга нар, мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай

3. Мал угаалгын ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, мал угаалгын ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

4. Мал угаалгын ажлыг технологит хугацаанд нь мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн газар (И.Жавхлант), захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



Аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 21-ны  
 өдрийн 759 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



УГААЛГЫН АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДАХ  
 МАЛЫН ТОО

№	Сумын нэр	Багын тоо	1.Угаалга /мян.тол/			
			Бод	Бог		Нийт
			Үхэр	Хонь	Ямаа	
Хэмжих нэгж		(мян/т)				
1	Адаацаг	5	0	42500	42500	85000
2	Баянжаргалан	3	0	55000	42000	97000
3	Говь-Угтаал	4	0	18000	18000	36000
4	Гурвансайхан	4	0	50000	40000	90000
5	Дэлгэрхангай	4	0	57993	89119	147112
6	Дэлгэрцогт	3	0	60600	57400	118000
7	Дэрэн	4	0	48000	42000	90000
8	Луус	3	0	45000	45000	90000
9	Өлзийт	6	0	186000	157000	343000
10	Өндөршил	3	0	50000	50000	100000
11	Сайхановоо	4	0	40040	44835	84875
12	Сайнцагаан	9	0	92000	76000	168000
13	Хулд	4	0	57000	57000	114000
14	Цагаандэлгэр	4	0	36000	25000	61000
15	Эрдэнэдалай	7	0	101996	89793	191789
16	<b>Бүгд</b>	<b>67</b>	<b>0</b>	<b>940129</b>	<b>875647</b>	<b>1815776</b>

Аймгийн Засаг даргын 2024 оны 03-р сарын 02-ны  
өдрийн Ассэс дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**Малын шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх мал угаалгын арга  
хэмжээг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих ажлын удирдамж**

**Зорилго** Малын шимэгчтэх өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, малд тарга тэвээрэг бүрэн авхуулах, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор мал сүргийг угаалгад хамруулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

**Хугацаа:** Мал угаалгын ажлыг 2024 оны 07 сараас 01-нээс 2024 оны 09 сарын 30 хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ

**Хэрэгжүүлэх бүрэлдэхүүн:** Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд, Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн малын эмч нар, малчид, мал бүхий иргэд, аж ахуй нэгж хамтран хэрэгжүүлнэ.

**Гүйцэтгэх ажил**

**Мал эмнэлгийн тасаг:**

1. Мал угаалгын арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, угаалгад төлөвлөгөөний дагуу бог малыг бүрэн хамруулах
2. Сумын Засаг даргын захирамж гарган, Багийн Засаг дарга нар мал угаалгын ажлын зар товыг хүргэх, мал угаалгыг идэвхжүүлэх малчдын оролцоог хангах, малын эмч нарт дэмжлэг үзүүлэх
3. Малын шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
4. Мал угаалгын арга хэмжээг гэрээт нэгжүүд мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх итгэмжлэлтэй малын эмчээр гүйцэтгүүлэх,
5. Шимэгчтэх өвчний тархалт, халдварлалтын байдал нь малчны эдийн засаг нийтийн эрүүл мэндэд үзүүлэх хор, хохирлын талаар сурталчилгаа, мэдээлэл хийх
6. Орон нутагт байгаа мал угаалгын ванны судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж 2024 оны 07 сарын 10-ны дотор явуулах

**Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж:**

1. Мал угаалгын арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, угаалгад төлөвлөгөөний дагуу бог малыг бүрэн хамруулах
2. Шимэгчтэх өвчний тархалт, халдварлалтын байдал нь малчны эдийн засаг нийтийн эрүүл мэндэд үзүүлэх хор, хохирлын талаар сурталчилгаа, мэдээлэл хийх
3. Угаалгад шаардагдах эм, бэлдмэлийн тооцоо судалгааг гаргаж, Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн

сорилт, баталгаажуулалтын дүнтэй шимэгчтэх өвчний эм бэлдмэлүүдээр угаалгын ажлыг гүйцэтгэх

4. Бог мал угаах суурин байгууламжийн MNS 6938:2021 стандартын дагуу орон нутагтаа шинээр мал угаалгын ванн бариулах, баригдсан суурин ванныг засварлах, баригдсан ванны ашиглаг бог малын шумбуулж угаахыг чухалчлах.

**Мэдээ тайлагналт:**

1. Сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн нар шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг цахим системд төлөвлөх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нар арга хэмжээний гүйцэтгэлийг цахим системд тухай бүрд нь шивж илгээх, гүйцэтгэлийг оруулахдаа хавсралт хэсэгт хэрэглэсэн бэлдмэлийн зургийг бодитой үнэн зөв оруулах,
2. Мал эмнэлгийн газар, мал эмнэлгийн тасгаас мал угаалгын ажлын явц, эмийн бодисын хэрэглээнд 2-оос доошгүй удаа газар дээр нь, нэгдсэн системийн гүйцэтгэл оруулж буй байдалд өдөр тутам хяналтыг тавьж ажиллах,
3. Мал угаалгын арга хэмжээний явцын мэдээг графикт хугацаанд нь батлагдсан маягт, цахим ашиглан ирүүлэх 7 хоног бүрийн 3 дахь өдрийн 12 цагаас өмнө [malemneleg2020@gmail.com](mailto:malemneleg2020@gmail.com), болон динамик хаягаар ирүүлж байх, угаалгын эцсийн мэдээ тайланг 2024 оны 8 сарын 15-ны дотор ирүүлэх
4. Мал угаалга хийсэн айл өрх бүр дээр угаалгын акт, хашаа хорооны актны зураг хавсаргах

**Хариуцлага:**

1. Мал угаалгын арга хэмжээг сум багтаа товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг зөрчлийн тухай хуулийн дагуу хоёр мянган нэгжтэй /2 сая төгрөг/ тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
2. Мал угаалга ажлыг өөрсдөө хийсэн малчдад хариуцлага тооцох, угаалганд мал сүргээ хамруулаагүй малчдаас амьд мал, мах, махан бүтээгдэхүүний зах зээлд гаргахгүй, мал эмнэлгийн гэрчилгээ олгохгүй байх

**МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР**